



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ӨРИЙГ БҮРТГЭХ, ТӨЛҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДСОН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛСАН ЖУРАМ

Баримт бичгийн дугаар: ЖРМ-ХШГ-.... -2026

Баталсан: Нийгмийн даатгалын
ерөнхий газрын дарга **Б.БАТЖАРГАЛ**

Хянасан: Хяналт шалгалтын
газрын дарга **С.ЛХАГВАДОРЖ**

Боловсруулсан: Хяналт шалгалтын
газрын Шимтгэлийн орлого,
өрийн хяналтын арга зүйн
хэлтсийн ахлах мэргэжилтэн **Э..АЗМАА**

Шимтгэлийн орлого,
өрийн хяналтын арга зүйн
хэлтсийн мэргэжилтэн **Д.БАЯРСАЙХАН**

Эх хувь	Дардас
Хяналттай хувь	
Хуулбар хувь	
Хүчингүй хувь	
Хяналтгүй хувь	



Баримт бичгийн үндсэн мэдээлэл

Баримт бичгийн хариуцагч	Тушаалын дугаар	Баталсан огноо	Мөрдөж эхлэх огноо	Хуудасны тоо
НДЕГ-ын ХШГ				

Өөрчлөлтийн тухай тэмдэглэл

Нэмэлт өөрчлөлт	Өөрчлөлт оруулсан огноо	Өөрчлөлтийн утга	Өөрчлөлт оруулсан ажилтан
Хувилбар 1			
Хувилбар 2			
Хувилбар 3			
Хувилбар 4			
Хувилбар 5			
Хувилбар 6			



АГУУЛГА

1. Нийтлэг үндэслэл
2. Нэр томьёо, хэрэглэх хүрээ
3. Шимтгэлийн өрийг тодорхойлох, бүртгэх, насжилтаар ангилах
4. Шимтгэлийн өр барагдуулах арга хэмжээний шатлал
5. Шимтгэлийн өрийг төлүүлэх арга хэмжээ
6. Хяналт
7. Хариуцлага

ТӨСӨГ



ТӨСӨЛ

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
202... оны ... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ӨРИЙГ БҮРТГЭХ, ТӨЛҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДСОН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛСАН ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь нийгмийн даатгалын шимтгэл төлөгч (цаашид "ажил олгогч" гэх) нь хуульд заасан хугацаанд сар бүр нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын санд төлөөгүйгээс үүссэн нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг (цаашид "шимтгэлийн өр" гэх) бүртгэх, насжилтаар нь ангилах, барагдуулах үйл ажиллагааг зохион байгуулахад оршино.

Хоёр. Нэр томьёо, хэрэглэх хүрээ

2.1. Энэхүү журмаар Нийгмийн даатгалын ерөнхий хууль, холбогдох дээд шатны журам болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг төлүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

2.2. Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага, нийгмийн даатгалын улсын байцаагч, байцаагч, ажил олгогч, даатгуулагчид хамаарна.

2.3. Шимтгэлийн өр үүссэн хугацаа (өрийн насжилтын хугацаа) гэж шимтгэл төлөх хуульд заасан хугацааны дараагийн сарын 01-ний өдрөөс эхлэн тооцохыг хэлнэ.

2.4. Хавсралт маягтууд (загвар) нь энэхүү журмын салшгүй бүрэлдэхүүн хэсэг байна.

Гурав.Шимтгэлийн өрийг тодорхойлох, бүртгэх, насжилтаар ангилах

3.1. Ажил олгогчийн шимтгэлийн өрийг мэдээллийн санд бүртгэхдээ тухайн сард төлсөн шимтгэлийг хамгийн их хоногийн насжилттай өрөөс суутган тооцож, бүртгэлд тусгана.

3.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг ажил олгогч хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийг төлөөгүй, эсхүл дутуу төлсөн тохиолдолд ажил олгогчийн ирүүлсэн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан болон шимтгэл төлсөн мэдээлэлд үндэслэн тооцож, төлөгдөөгүй хугацаагаар нь дараах байдлаар ангилна.Үүнд:

- 3.2.1. 30 хүртэл хоног /1 сар/-ийн насжилттай;
- 3.2.2. 31-90 хүртэл хоног /1–3 сар/-ийн насжилттай;
- 3.2.3. 91-180 хоног /3–6 сар/-ийн насжилттай;
- 3.2.4. 181-270 хоног /6–9 сар/-ийн насжилттай;
- 3.2.5. 271-1 хүртэл жилийн насжилттай;
- 3.2.6. 1–2 хүртэл жилийн насжилттай;
- 3.2.7. 2–3 хүртэл жилийн насжилттай;
- 3.2.8. 3–4 хүртэл жилийн насжилттай;
- 3.2.9. 4–5 хүртэл жилийн насжилттай;



3.2.10. 5 жилээс дээш насжилттай шимтгэлийн өр гэж тус тус ангилна.

3.3 Шимтгэлийн өрийн насжилтын хугацааг дараах эрсдэлийн түвшингээр авч үзнэ.

Өрийн насжилтын хугацаа

3.3.1 0-30 хоног

3.3.2 31-90 хоног

3.3.3 91-180 хоног

3.3.4 181-365 хоног

3.3.5 365 хоногоос дээш

Эрсдэлийн түвшин

Бага эрсдэлтэй

Дунд эрсдэлтэй

Эрсдэлтэй

Өндөр эрсдэлтэй

Маш өндөр эрсдэлтэй.

Дөрөв. Шимтгэлийн өр барагдуулах арга хэмжээний шатлал

4.1. Ажил олгогчийн нийгмийн даатгалын санд төлсөн төлбөрөөс шимтгэл, алданги, торгуулийг дор дурдсан дарааллын дагуу суутган тооцож өрийг барагдуулна. Үүнд:

4.1.1. Шимтгэл төлөлтийн сарын тайлан (НД-7)-д тусгагдсан нийгмийн даатгалын шимтгэлийн үлдэгдлийн хэмжээгээр;

4.1.2. Улсын байцаагчийн актаар тогтоосон шимтгэл, алданги;

4.1.3. Шүүхийн шийдвэрээр тогтоосон шимтгэл, алданги, торгуулийн хэмжээгээр;

4.1.4. Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэлийн хуудсаар ногдуулсан торгууль;

4.2 Ажил олгогч энэ журмын 4.1-д заасан торгууль, шимтгэл, алдангийг нийгмийн даатгалын сангийн харилцах дансанд тусад нь шилжүүлж төлбөрийн даалгаварт шимтгэл, алдангийг тодорхой бичнэ.

Тав. Шимтгэлийн өрийг төлүүлэх арга хэмжээ

5.1. Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг төлүүлэх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

5.1.1. Ажил олгогч шимтгэлийн 30 хүртэл хоногийн өртэй тохиолдолд тухайн сарын тайлангаар ногдуулсан шимтгэл, үүнээс хуулийн хугацаанд төлөөгүй шимтгэлийн хэмжээгээр өрийг тооцон, мэдээллийн цахим системээр сануулгыг цахимаар хүргүүлнэ.

5.1.2. Ажил олгогч 31-90 хоногийн хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй тохиолдолд ажил олгогчийн удирдлагатай уулзалт зохион байгуулж, “Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага барагдуулах уулзалтын тэмдэглэл” (Маягт №01)-ийг үйлдэж баталгаажуулна. Уулзалтын тэмдэглэлд өрийг барагдуулах хугацаа, төлөлтийн хуваарийг тусгаж, тогтоосон хугацаанд өрийг барагдуулаагүй тохиолдолд нийгмийн даатгалын улсын байцаагч албан шаардлага хүргүүлж, уг шаардлагад заасан хугацаанд буюу 14 хоногийн дотор өрийг барагдуулахыг үүрэг болгож, биелэлтэд хяналт тавина.

5.1.3. Ажил олгогч шимтгэлийн 91-180 хоногийн өртэй тохиолдолд урьдчилсан мэдэгдэл /маягт №02/-ийг портал систем (portal.ndaatgal.mn), цахим шуудан, шуудан холбоо болон бусад боломжит мэдээллийн хэрэгсэлээр ажил олгогчийн удирдлага, нягтлан бодогчид хүргүүлнэ. Шимтгэлийн өрийг бүрэн төлж дуусах хүртэлх хугацаанд ажил олгогч, компанийн хувьцаа эзэмшигч (хувь хүн)-ийн банканд дахь “Харилцах дансны зарлагын гүйлгээг түр зогсоож, шимтгэл, алданги төлүүлэх тухай мэдэгдэл” (Маягт №03)-ийг арилжааны банканд цахимаар хүргүүлж, шимтгэлийн өрийг ажил олгогч болон хувьцаа эзэмшигч (хувь нийлүүлэгч)-ийн



данснаас үл маргах журмаар гаргуулна. Шимтгэлийн өрийг барагдуулсан тохиолдолд “Дансны зарлагын гүйлгээг нээх зөвшөөрөл” (Маягт №04)-ийг арилжааны банкинд цахимаар хүргүүлнэ.

Санамж.1.Данс битүүмжилсэн ажил олгогчийн төлбөр бүрэн барагдаагүй, дансыг нээгээгүй тохиолдолд тухайн ажил олгогчийн дансуудыг дахин нэмж хаахгүй байх, мэдэгдэл, зөвшөөрлийн дугаарыг давхардуулахгүй, засварлахгүй байх.

5.1.4 Ажил олгогч шимтгэлийн 181-270 хоногийн өртэй тохиолдолд өрийг үе шаттай барагдуулах, 90 хоног хүртэлх насжилттай шимтгэлийн өрийн дүнгээс 20 ба түүнээс дээш хувь, 91 хоногоос дээш насжилттай шимтгэлийн өрийн дүнгээс 30 ба түүнээс дээш хувийг урьдчилан төлсөн тохиолдолд “Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах гэрээ” /Маягт №05/-г зургаа хүртэлх сарын хугацаагаар байгуулж болно.

Санамж.2. Гэрээг байгуулахдаа тухайн тайлант онд шимтгэлийн өрийг бүрэн төлж дуусахаар тусгах, гэрээг он дамнуулан байгуулахгүй бөгөөд тайлант жилийн 12 дугаар сард шинээр гэрээ байгуулахгүй.

5.1.5 Энэ журмын 5.1.4-т заасан хугацаанд гэрээний үүргийг зөрчөөгүй, үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа ажил олгогчийн үйл ажиллагааны чиглэлийн онцлог, ажлын гүйцэтгэлийн үр дүнгээр санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхой хугацаагаар хойшлогдсон бол гэрээг 3 хүртэл сарын хугацаагаар нэг удаа сунган шийдвэрлэж болно.
/оруулах эсэхийг асуух/

Санамж:3. Гэрээ байгуулсан нь банкин дахь дансны зарлагын гүйлгээг нээх, даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж, төлбөр зардал олгох, алданги торгуулиас чөлөөлөх үндэслэл болохгүй.

Санамж:4. Ажил олгогч гэрээний үүргээ зөрчсөн тохиолдолд нийгмийн даатгалын байгууллага гэрээг хугацаанаас нь өмнө нэг талын санаачлагаар цуцлах бөгөөд ажил олгогчтой дахин шимтгэл төлөлтийн гэрээ байгуулахгүй.

Санамж:5.Гэрээний үүргээ зөрчсөн ажил олгогчийг шүүхэд гаргасан нэхэмжлэлийн ажиллагаанд Нийгмийн даатгалын байгууллага эвлэрлийн гэрээ байгуулахгүй байх зарчмыг баримтлана. /Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар талууд шүүхийн ажиллагааны явцад эвлэрэх эрхтэй. / АСУУХ/

5.1.5. Ажил олгогч шимтгэлийн 271 хоногоос дээш өртэй тохиолдолд “Шүүхийн байгууллагад шилжүүлэх тухай мэдэгдэл” (Маягт №06)-ийг хүргүүлнэ. Мэдэгдэлд заасан хугацаанд шимтгэлийн өрийг барагдуулаагүй бол хууль, журмын дагуу өрийг төлүүлэх тухай нэхэмжлэл, хүсэлтийг шүүхийн байгууллагад гаргана.

5.1.6. Шүүхэд нэхэмжилсэн шимтгэлийн авлагыг тухайн ажил олгогч нь шүүхийн шийдвэр гаргуулахгүйгээр тодорхой эх үүсвэрээр төлөх боломжтойгоо нотолж, албан есны хүсэлтээ гаргасан гаргасан тохиолдолд уг өрийг барагдуулах тухай Эвлэрлийн гэрээг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасан журмаар 3 сарын хугацаатай байгуулж болно. Ажил олгогч нь Эвлэрлийн гэрээнд заасан хугацаанд шимтгэлийн өрийг төлөөгүй тохиолдолд уг өрийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах зарчмыг баримталх /энэ заалт байх эсэхийг асуух/



5.2 Ажил олгогч нь тайлангаар ногдуулсан төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг хуульд заасан хугацаанд төлөөгүй, эсхүл дутуу төлсөн бол хугацаандаа төлөөгүй, дутуу төлсөн шимтгэлийг нөхөн төлүүлэхээр нийгмийн даатгалын улсын байцаагч хуульд заасан эрхийн хүрээнд өр үүссэн хугацаа, өрийн насжилтаас үл хамааран Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.2-т заасны дагуу улсын байцаагчийн акт тогтоож, алданги тооцох, Зөрчлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.17.3-т заасан хариуцлага хүлээлгэх зэрэг хуульд заасан бусад арга хэмжээ авч болно.

Санамж:6. Шимтгэлийн өрийг төлүүлэх, зөрчлийг арилгуулах зорилгоор нийгмийн даатгалын Улсын байцаагчийн акт тогтоохдоо Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.2 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 94.1 дэх хэсэг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 184.1, 184.3 дахь хэсгийг актад дурдаж өгнө.

5.3 Ажил олгогчийн үйл ажиллагаа зогссон, татан буугдах, дампуурлын ажиллагаа эхэлсэн, эд хөрөнгөө бусдад шилжүүлсэн, төлбөрийн чадваргүй болох, шимтгэлийн өрийг сайн дураар барагдуулах боломжгүй, оршин байгаа хаягтаа байхгүй гэж үзсэн тохиолдолд энэ журмын 5.1-т заасан арга хэмжээний хугацаа, дарааллыг харгалзахгүйгээр шимтгэлийн өрийг гаргуулах тухай нэхэмжлэл, хүсэлтийг шүүхэд гаргаж болно.

5.4. Шимтгэлийн өртэй ажил олгогчийн мэдээллийг “Монголбанкны зээлийн мэдээллийн санд ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх мэдээллийг хүргүүлэхэд баримтлах журам”-д зааснаар Монголбанкны зээлийн мэдээллийн санд хүргүүлнэ.

5.5. Нийгмийн даатгалын байгууллага нь шимтгэлийн өр барагдуулах үйл ажиллагаатай холбоотой, улсын байцаагчийн акт, албан шаардлага, өр барагдуулах гэрээ, урьдчилсан мэдэгдэл, шүүхийн байгууллагад хүргүүлэх урьдчилсан мэдэгдэл, данс хаах мэдэгдэл, нээх зөвшөөрөл, шүүхийн шүүхийн шийдвэр зэргийг ажил олгогчийн цахим хувийн хэрэгт хавсарган, мэдээллийн системд бүртгэн тухай бүх баяжилт хийнэ.

Зургаа. Хяналт

6.1. Шимтгэлийн өрийг төлүүлэх үйл ажиллагаанд нийгмийн даатгалын байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллана.

Долоо.Хариуцлага

7.1 Нийгмийн даатгалын байгууллага нь шимтгэлийн өр барагдуулахтай холбоотой асуудлаар хөнгөлөлттэй худалдаа, бэлэг шан харамжийн зүйл болон бусад хууль бус хангамж, урамшуулал авахыг хориглоно.

7.2. Нийгмийн даатгалын байгууллага, албан тушаалтан нийгийн даатгалын шимтгэлийн өрийг төлүүлэх үйл ажиллагаанд ажилтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.



Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн
“Маягтын загвар шинэчлэн батлах тухай” А/06 дугаар тушаал,
2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/83 “Маягтын загвар батлах тухай” А/83 дугаар
тушаалыг тус тус хүчингүй.

ТӨСӨГ



Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг бүртгэх, төлүүлэхтэй холбогдсон
харилцааг зохицуулсан журам ЖРМ-ХШГ-.... -2026

Маягт №01

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН АВЛАГА БАРАГДУУЛАХ
УУЛЗАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ

202... оны ... сарын ... өдөр

Дугаар

.....аймаг, /хот/

1. Ажил олгогчийн нэр: Өмчийн хэлбэр..... Регистр.....

2. НДШ-н авлагын хэмжээ:..... 3. Авлага үүссэн огноо

4. Уулзалт хийсэн ажил олгогчийн ажилтны:

Албан тушаал :..... Овог, нэр:.....

5. Уулзалтанд оролцсон НДБ-ын ажилтнуудын нэрс, албан тушаал:

1.....

2.....

6. Өмнө авсан арга хэмжээ: /зур/ Утсаар мэдэгдсэн ☐ Бусад ☐

Улсын байцаагчийн албан шаардлага ☐ Дансны зарлагын гүйлгээг түр зогсоох мэдэгдэл ☐

Өр барагдуулах гэрээ ☐ Шүүхэд ☐

7. Уулзалтаар хийсэн ярианы товч тэмдэглэл:

а) Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын танилцуулга, авлага барагдуулах хугацаа;

б) Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32.2.6, 33.1.6, 38.10.6 дахь заалт;

в) Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйл;

г) Эрүүгийн хуулийн 18.14 дүгээр зүйл;

д) Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан “Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг бүртгэх, төлүүлэхтэй харилцааг зохицуулсан журам”;

е) Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8, 4.1.11, 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалтын хүрээнд нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй ажил олгогчийн мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд оруулах зэрэг хууль тогтоомжуудыг танилцуулсан.

8. Ажил олгогчийн санал:

.....

9. Шийдвэрлэсэн нь:

.....

САНАМЖ: Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32.2.6, 33.1.6-д заасны дагуу шимтгэлийн өртэй хугацаанд даатгуулагчдад олгох тэтгэвэр, тэтгэмжийг танай байгууллага хариуцах болохыг анхаарна уу.

Тэмдэглэл хөтөлсөн:

/ албан тушаал / / овог, нэр утас

Танилцаж зөвшөөрсөн:

НД-ын байгууллагын төлөөлөл:

/ албан тушаал /тэмдэг/ / овог, нэр утас

Ажил олгогчийн төлөөлөл:

/ албан тушаал /тэмдэг/ / овог, нэр утас



УРЬДЧИЛСАН МЭДЭГДЭЛ

202.. оны ...сарын ... өдөр №...аймаг,/хот/

Ажил олгогчийн регистр Ажил олгогчийн нэр:.....

Захирал /дарга/ танаа

Танай байгууллага ньоны сарын-ний өдрийн байдлаар төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр /цаашид “шимтгэлийн өр” гэх/ үүсгэсэн тул уг өрийг төлүүлэхээр Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.2, 32.2.5, Засгийн газрын 2023 оны 469 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “Нийгмийн даатгалын улсын байцаагчийн дүрэм”-ийн 3.1-д заасны дагуу харилцах банкн дахь зарлагын гүйлгээг түр зогсоох талаар урьдчилсан мэдэгдлийг хүргүүлж байна. Мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор шимтгэлийн өрийг төлж барагдуулна уу.

Шимтгэлийн өрийг энэхүү мэдэгдэлд заасан өдрийн дотор барагдуулаагүй тохиолдолд танай байгууллагын харилцагч банкн дахь төгрөгийн болон валютын харилцах дансны зарлагын гүйлгээг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан “Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг бүртгэх, төлүүлэхтэй харилцааг зохицуулсан журам”-д заасны дагууоны.....-р сарынны өдрөөс эхлэн түр зогсоож, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 38 дугаар зүйлийн 38.10.4, 44 дүгээр зүйлийн 44.1.2, Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4 дэх заалтад тус тус заасны дагуу дээрх төлөгдөөгүй шимтгэл, алдангийг харилцах данснаас үл маргах журмаар гаргуулахыг мэдэгдье.

Шимтгэлийн өрийг төлөөгүйн улмаас танай байгууллагын ажилтан, даатгуулагч нь нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр авч чадаагүй тохиолдолд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32.2.6, 33.1.6-д заасны дагуу тухайн даатгуулагчид учирсан хохирлыг танай ажил олгогч бүрэн хариуцан төлөх үүрэгтэй болохыг сануулж байна.

Мэдэгдэл үйлдсэн:

.....аймаг/дүүрэг/-ийн Нийгмийн даатгалын газрын Хамралт орлогын
хэлтсийн дарга // Утас :

гарын үсэг овог, нэр

Нийгмийн даатгалын байцаагч // Утас :

гарын үсэг овог, нэр

Хүргүүлсэн тэмдэглэл: ☐ биечлэн ☐ шуудан ☐ цахим хэлбэрээр



Маягт №03

“ АРИЛЖААНЫ БАНКУУДАД ”

“ Дансны зарлагын гүйлгээг түр зогсоож,
шимтгэл, алданги төлүүлэх тухай

..... регистрийн дугаартайНЬ
(байгууллагын нэр)

Нийгмийн даатгалын шимтгэлтөгрөг, алданги.....төгрөг, нийттөгрөг
(.....)-ийг 202...оны...сарын.....ны өдрийн байдлаар төлөөгүй байна.
(мөнгөн дүн бичгээр)

Иймд тус байгууллагын эзэмшиж буй төгрөгийн болон валютын дансны зарлагын
гүйлгээг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан “Нийгмийн даатгалын
шимтгэлийн өрийг бүртгэх, төлүүлэхтэй харилцааг зохицуулсан журам”-д заасны дагуу
20..... оны –р сарын-ны өдрөөс эхлэн түр зогсоож, Нийгмийн даатгалын ерөнхий
хуулийн 38 дугаар зүйлийн 38.10.4, Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4 дэх
хэсэгт тус тус заасны дагуу дээрх төлөгдөөгүй шимтгэл, алдангийг уг байгууллагын
.....банкны.....тоот
/салбартай тохиолдолд/

данснаас үл маргах журмаар гаргуулж.....аймаг/дүүргийн Нийгмийн даатгалын
газрын банкн дахь.....тоот дансанд шилжүүлэхийг мэдэгдье.

Нийгмийн даатгалын шимтгэл, алдангийг бүрэн төлж, тооцоо хийж дууссан нөхцөлд
дансны зарлагын гүйлгээг нээх зөвшөөрлийг олгоно.

Үйлдсэн:

..... аймаг/дүүрэг-ийн
нийгмийн даатгалын байцаагч: /...../ Утас.
.....
(гарын үсэг) (овог, нэр)

Хянасан:

..... хэлтсийн дарга: /...../ Утас.....
(гарын үсэг) (овог, нэр)

Хүргүүлсэн тэмдэглэл: ☐- цахим хэлбэрээр ☐-цаасан хэлбэрээр



Маягт №04

“ АРИЛЖААНЫ БАНКУУДАД ”

“Дансны зарлагын гүйлгээг нээх тухай ”

..... регистрийн дугаартайНЬ
(байгууллагын нэр)
.....оны.....сарын.....-ны өдрийн.....дугаар “Мэдэгдэл”-ийн дагуу нийгмийн даатгалын
шимтгэл, алданги(.....) төгрөгийг нийгмийн
(мөнгөн дүн бичгээр)
даатгалын санд төлсөн тул тус байгууллагын төгрөгийн болон валютын дансны зарлагын
гүйлгээг 20..... оны-р сарын-ны өдрөөс эхлэн нээхийг зөвшөөрөв.

Үйлдсэн:

..... аймаг/дүүрэг-ийн
Нийгмийн даатгалын байцаагч: /...../ Утас.
.....
(гарын үсэг) (овог, нэр)

Хянасан:

..... хэлтсийн дарга: /...../
Утас.....
(гарын үсэг) (овог, нэр)

Хүргүүлсэн тэмдэглэл: ☐ - цахим хэлбэрээр ☐ -цаасан хэлбэрээр



БАТЛАВ

..... АЙМАГ, ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА

Гарын үсэг, ГАРЫН ҮСГИЙН ТАЙЛАЛ

..... оны дугаар сарын

БАТЛАВ

.....
АЖИЛ ОЛГОГЧИЙН ЗАХИРАЛ

Гарын үсэг, ГАРЫН ҮСГИЙН ТАЙЛАЛ

..... оны дугаар сарын

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ӨРИЙГ БАРАГДУУЛАХ ГЭРЭЭ

202 он сарын өдөр

№ аймаг /хот/

Нэг талаас аймаг/дүүрэг/-ийн Нийгмийн даатгалын газар, /цаашид Нийгмийн даатгалын байгууллага гэх/ нөгөө талаас регистрийн дугаартай ажил олгогч /цаашид “ажил олгогч гэх/ хамтад нь /талууд гэх/ нар харилцан тохиролцож Иргэний хуулийн 72, 73 дугаар зүйл, 186 дугаар зүйлийн 186.1, 189.1 дэх хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.2, 31 дүгээр зүйл, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан “Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг бүртгэх, төлүүлэхтэй харилцааг зохицуулсан журам”-ыг тус тус удирдлага болгон энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Тус гэрээний зорилго нь ажил олгогчид даатгуулагчдын нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг төлөх, нийгмийн даатгалын сан болон даатгуулагчид учирч болох эрсдэлийг бууруулах, ажил олгогч, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхтэй холбоотой талуудын хооронд үүссэн харилцааг зохицуулахад оршино.

1.2. Гэрээнд заасан шимтгэлийн өрийн дүн болон төлөх хугацааг авсралтаар батлах бөгөөд уг хавсралт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

Хоёр. Шимтгэлийн өрийг төлж барагдуулах хугацаа

2.1.Гэрээний хугацааг хоёр тал дор дурдсанаар харилцан тохиролцож тогтоох бөгөөд хуанлийн тооллыг удирдлага болгоно.

2.2.Хоёр талын эрх бүхий албан тушаалтан гэрээнд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулсан тухайн он, сар, өдрөөс эхэлж шимтгэлийн өрийг төлж барагдуулах хугацааг тоолно.



Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг бүртгэх, төлүүлэхтэй холбогдсон
харилцааг зохицуулсан журам ЖРМ-ХШГ-..... -2026

2.3.Талуудын харилцан тохиролцсон буюу хавсралтад заасан хугацаанд шимтгэлийн өрийг бүрэн барагдуулж дууссанаар гэрээ дуусгавар болно.

Гурав. Нийгмийн даатгалын байгууллагын эрх, үүрэг

3.1. Нийгмийн даатгалын байгууллага дараах эрхтэй. Үүнд:

3.1.1.Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг зөрчсөн ажил олгогчид хуульд заасан хариуцлага хүлээлгэх;

3.1.2.Энэ гэрээний хавсралтад заасан шимтгэлийн өр болон гэрээ байгуулснаас хойших хугацааны шимтгэлийн тооцоог тухайн сард нь багтаан хугацаандаа төлж барагдуулаагүй тохиолдолд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.2 дахь заалтын дагуу хариуцлага тооцож, барагдуулаагүй шимтгэлийн дүн болон түүнд ногдуулсан алдангийн хамт ажил олгогчийн харилцагч банкны дансны зарлагын гүйлгээг зогсоох замаар үл маргах журмаар гаргуулах;

3.1.3.Гэрээнд заасан хугацаа эхэлснээс хойш хугацаанд ажил олгогч гэрээний үүргээ үл биелүүлж шимтгэлийн өрийг хавсралтад заасан хугацаанд төлөөгүй, төлөхөөс зайлсхийсэн, хайхрамжгүй хандсан тохиолдолд гэрээний хугацааны аль ч үед үл маргах журмаар гэрээг дангаар цуцлах;

3.1.4. Нийгмийн даатгалын байгууллага гэрээг дангаар цуцлах тохиолдолд ажил олгогчид цахим хэлбэрээр мэдэгдсэнээр гэрээг цуцлах;

3.1.5.Ажил олгогч гэрээнд заасан хугацаанаас өмнө шимтгэлийн өрийг бүрэн төлсөн тохиолдолд гэрээг дуусгавар болгоно;

3.1.6.Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг зөрчсөн, гэрээний үүргээ биелүүлээгүй бол ажил олгогчид харилцах дансны зарлагын гүйлгээг түр зогсоох “Урьдчилсан мэдэгдэл”-ийг хүргүүлж, мэдэгдэлд заасан хугацаанд шимтгэлийн өрийг төлж барагдуулаагүй бол данс хаах мэдэгдлийг харилцагч банкуудад хүргүүлж, шимтгэл, алдангийг үл маргах журмаар гаргуулах, улмаар “Шүүхийн байгууллагад шилжүүлэх тухай урьдчилсан мэдэгдэл”-ийг хүргүүлж, холбогдох хууль тогтоомжийн дагуу хууль, шүүхийн байгууллагад нэхэмжлэл гаргах;

3.1.7.Гэрээ байгуулсан ажил олгогч нь нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулаагүй тохиолдолд Нийгмийн даатгалын байгууллага гэрээг цаашид сунгахгүй болно.

3.2.Нийгмийн даатгалын байгууллага дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

3.2.1.Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчилан таниулах, олон нийтэд чиглэсэн сурталчилгаа, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж мэргэжлийн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах зэрэг болно.

Дөрөв. Ажил олгогчийн эрх, үүрэг

4.1. Ажил олгогч дараах эрхтэй. Үүнд:

4.1.1.Нийгмийн даатгалын байгууллагын хууль зөрчсөн үйл ажиллагаа, шийдвэрийн талаарх гомдлыг эрх бүхий дээд шатны байгууллага, албан тушаалтанд гаргах;

4.1.2.Нийгмийн даатгалын байгууллагаас холбогдох хууль тогтоомж болон бусад мэдээлэл, зөвлөгөө авах;

4.1.3.Гэрээнд заасан шимтгэлийн өрийг барагдуулах талаар тохирсон хуваарийг хугацаанаас өмнө шимтгэлийн өрийг төлж барагдуулах.

4.2.Ажил олгогч дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

4.2.1.Шимтгэлийн өр.....төгрөгийг энэхүү гэрээний хавсралтад заасан хуваарьт хугацаанд, гэрээ байгуулснаас хойших хугацаанд шинээр үүссэн шимтгэлийг тухайн сард нь багтаан төлөх;



Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг бүртгэх, төлүүлэхтэй холбогдсон
харилцааг зохицуулсан журам ЖРМ-ХШГ-.... -2026

4.2.2. Ажил олгогч нь нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэснээр даатгуулагчид учирсан хохирлыг Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.6 дахь заалтад заасны дагуу бүрэн хариуцаж төлөх;

4.2.3. Ажил олгогч үйл ажиллагаа явуулж байгаа хаяг болон улсын бүртгэлд бүртгэгдсэн хаяг, холбогдох утасны дугаар, гүйцэтгэх удирдлагын хаяг, утасны дугаарыг нийгмийн даатгалын байгууллагад үнэн зөв мэдүүлэх;

4.2.4. Энэ гэрээний 4.2.3-т заасан мэдээлэл гэрээний хугацаанд өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр Нийгмийн даатгалын байгууллагад мэдэгдэх.

Тав. Талуудын хүлээх хариуцлага

5.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлж гэрээг хугацаанд нь гүйцэтгэх эрх ашгийн төлөө хамтран ажиллана.

5.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нөхөн төлөх үүрэг хүлээх бөгөөд учруулсан хохирлыг хохирол учруулсан талд нөхөн төлснөөр гэрээний үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй ба гэрээний үүргээ бүрэн биелүүлснээр гэрээний үүргээс чөлөөлөгдөж дуусгавар болгох үндэслэл бүрэлдэнэ.

Зургаа. Бусад зүйл

6.1. Нийгмийн даатгалын байгууллага нь Ажил олгогч талын удирдлагын баг болон ажилтнаас энэхүү гэрээтэй холбогдуулан хөнгөлөлттэй худалдаа, бэлэг шан харамжийн зүйл болон бусад хууль бус хангамж, урамшуулал өгөхийг хориглоно. Хэрэв эдгээрийг шаардсан тохиолдолд үүнийг Ажил олгогч тал болон Нийгмийн даатгалын байгууллагын эрх бүхий албан тушаалтанд тус тус мэдээлэх үүрэгтэй.

6.2. Талууд гэрээ байгуулахдаа хувийн ашиг сонирхлоос ангид байж, холбогдох хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагааг явуулна.

6.3. Байгалийн давагдашгүй хүчин зүйл (дайн, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болсон, бослого үймээн гарсан, түймэр, үер, халдварт өвчин, хорио цээр, газар хөдлөлт, хүчтэй шороон болон цасан шуурга)-ийн улмаас аль нэг тал гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй байдалд хүрснээ харилцан хүлээж тухайн хугацааг гэрээний хугацаанд нэмж тооцно. Энэхүү нөхцөл байдал үүссэн тохиолдолд талууд тайлбар, нотлох баримтын хамт ажлын 5 өдрийн дотор албан бичгээр ирүүлнэ.

6.4. Гэрээ нь талуудын эрх, ашиг сонирхлын дагуу байгуулагдсан бөгөөд талуудын хувьд зайлшгүй дагаж мөрдөх баримт бичиг байна.

6.5. Гэрээг 3 хувь үйлдэж, Нийгмийн даатгалын байгууллага 1 хувийг архивт хадгаламжийн нэгж үүсгэн хадгалж, ажил олгогчийн нийгмийн даатгалын хувийн хэрэгт 1 хувь, ажил олгогч тал үлдсэн 1 хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

.....АЙМАГ/ДҮҮРЭГ/-ИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ:

/...../

АЖИЛ ОЛГОГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:

/...../

Хамралт, орлогын хэлтсийн дарга

/...../

албан тушаал, гарын үсэг, нэр

Хамралт, орлого, шимтгэлийн өр хариуцсан байцаагч

/...../

Утас:.....

Утас:.....



Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг бүртгэх, төлүүлэхтэй холбогдсон
харилцааг зохицуулсан журам ЖРМ-ХШГ-.... -2026

Нийгмийн даатгалын шимтгэлийн өр
барагдуулах 20 ... оны сарын -ны өдрийн
..... дугаар гэрээний хавсралт

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн хуваарь

(төгрөгөөр)

№	Төлөх сар	НДШ-ийн эхний үлдэгдэл	Төлөх дүн	Шимтгэлийн эцсийн үлдэгдэл
	XXX			

Тухайн сард үүсэх нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр төлөхийг анхаарна уу.

Нийгмийн даатгалын байгууллагыг
төлөөлж:

Хамралт, орлогын хэлтсийн дарга

/...../

гарын үсэг

нэр

Ажил олгогчийг төлөөлж:

/...../

албан тушаал

гарын үсэг

нэр



ШҮҮХИЙН БАЙГУУЛЛАГАД ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ МЭДЭГДЭЛ

202.. оны ...сарын ... өдөр

№...

.....аймаг,/хот/

Ажил олгогчийн регистр

Ажил олгогчийн нэр:.....

Захирал /дарга/ танаа

Танай байгууллага ньоны сарын-ний өдрийн байдлаар төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр /цаашид “шимтгэлийн өр” гэх/ үүсгэсэн тул уг өрийг төлүүлэхээр Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.2, 32.2.5, Засгийн газрын 2023 оны 469 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “Нийгмийн даатгалын улсын байцаагчийн дүрэм”-ийн 3.1-д заасны дагуу “Шүүхийн байгууллагад шилжүүлэх тухай урьдчилсан мэдэгдэл”-ийг хүргүүлж байна. Мэдэгдлийг хүлээн авсанаас хойш ажлын 10 өдрийн дотор шимтгэлийн өрийг төлж барагдуулна уу.

Шимтгэлийн өрийг энэхүү мэдэгдэлд заасан хугацаанд бүрэн барагдуулаагүй тохиолдолд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.2-т заасны дагуу дутуу төлсөн шимтгэлийн дүнгээс хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0.3 хувиар алданги тооцож, шимтгэл, алдангийн хамт төлүүлэх нэхэмжлэлийг холбогдох хуулийн байгууллагад гаргах болсоныг үүгээр мэдэгдье.

Шимтгэлийн өрийг төлөөгүйн улмаас танай байгууллагын ажилтан, даатгуулагч нь нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр авч чадаагүй тохиолдолд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32.2.6, 33.1.6-д заасны дагуу тухайн даатгуулагчид учирсан хохирлыг танай ажил олгогч бүрэн хариуцан төлөх үүрэгтэй болохыг сануулж байна.

Мэдэгдэл үйлдсэн:

.....аймаг/дүүрэг/-ийн Нийгмийн даатгалын газрын Хамралт орлогын
хэлтсийн дарга

/...../

Утас :

гарын үсэг

овог, нэр

Нийгмийн даатгалын байцаагч

/...../

Утас :

гарын үсэг

овог, нэр

Хүргүүлсэн тэмдэглэл: ☐ биечлэн ☐ шуудан ☐ цахим хэлбэрээр